



# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 36 (173)

## Яам агентлагийн акт:

- *Монгол Улсын Дэд бүтцийн улсын хяналтын албаны даргын тушаал*
- *Монгол Улсын сангийн сайдын тушаал*

Улсын Их Хурлын Тамгын газар

Улаанбаатар хот  
2000 он



# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот

2000 оны есдүгээр сарын 29

№36 (173)

## Гарчиг

### ЯАМ, АГЕНТЛАГИЙН АКТ

394. Дэд бүтцийн улсын хяналтийн албаны даргын тушаал	№ 68	671
395. Монгол Улсын Сангийн Сайдын тушаал	№ 33	672
396. Монгол Улсын Дэд бүтцийн хөгжлийн сайдын тушаал	№ 56	674

## ДЭД БҮТЦИЙН УЛСЫН ХЯНАЛТЫН АЛБАНЫ ДАРГЫН ТУШААЛ

2000 оны 5 дугаар сарын 26-ны өдөр

Дугаар 68

Улаанбаатар хот

### Журам батлах тухай

Дэд бүтцийн хөгжлийн сайдын 1999 оны 229 тоот тушаалаар батлагдсан "Авто тээврийн хэрэгслээр ачаа, зорчигч тээвэрлэх дүрэм"-ийн 5-р зүйлийн 92 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

"Авто тээврийн акт тавих журам"-ыг хавсралтын ёсоор баталсугай.

ДАРГА

Н.ЛХАГВАА

ДБУХА-ны даргын 2000 оны 68 тоот тушаалын хавсралт

### АВТО ТЭЭВРИЙН АКТ ТАВИХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Тээвэрлэгч, тээвэрлүүлэгч, зорчигч нь тээвэрлэлтийн талаар тогтоосон журмыг зөрчсөн тохиолдолд хууль тогтоомжийн дагуу буруутай этгээдийг тогтоож нөхөн төлбөр ногдуулахтай холбогдсон асуудлыг акт тогтоож шийдвэрлэхэд энэхүү журмыг баримтална.

2. Улсын байцаагчаас захиргааны хяналтыг хэрэгжүүлэх явцад илэрсэн зөрчлийг арилгуулах зорилгоор тээвэрлэгч, тээвэрлүүлэгч, зорчигчид учирсан хохирлын хэмжээ, түүнийг хариуцагч этгээд, нөхөн төлбөрийг хариуцуулах үндэслэл, төлөх хугацаа зэргийг Автотээврийн хяналтын улсын байцаагч хууль тогтоомжийг үндэслэн шалгасны үндсэн дээр акт тогтоож шийдвэрлэнэ.

3. Тээвэрлэгч, тээвэрлүүлэгч, зорчигчийн хүсэлт, шүүгчийн захирамжийг хэрэгжүүлэхтэй холбогдуулж тээвэрлэлтийн баримт бичгийг үндэслэн авто- тээврийн хэрэгслээр ачаа, зорчигч тээвэрлэх дүрмийн 80, 92 дугаар зүйлд зааснаар

улсын байцаагч акт тогтоож болно.

4. Тээвэрлэлтийн явцад үүссэн хохирлын хэмжээ, түүнийг хариуцах буруутай эзнийг тогтоож нөхөн төлүүлэх, хууль бусаар олсон орлогыг хураах, объектын үйл ажиллагааг бүхэлд нь буюу хэсэгчилсэн байдлаар зогсооход улсын байцаагчийн актыг үндэслэл болгоно.

5. Улсын байцаагч акт үйлдэхдээ тухайн хяналтын байгууллагын "Авто тээврийн хяналтын улсын байцаагчийн акт"-ын хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

Хоёр. Акт үйлдэх

1. Актын загвар нь зохион байгуулалт захирамжлалын баримт бичгийн улсын стандарт /Б.01.3-200/-ын дагуу толгойн бичвэрийн /тэмдэглэх, тогтоох/ баталгаажуулалтын хэсгээс бүрдэх ба түүнд дараахь зүйлийг заавал тусгана.

а/ Тэмдэглэх хэсэгт: Шалгасан аж ахуйн

нэгж, байгууллага объект, иргэний байршил, харъяалал, шалгах үед байлцуулсан хүний нэр, шалгасан үндэслэл, хугацаа;

-Шалгалтаар илэрсэн хохирол, зөрчил гарсан шалтгаан, зөрчигдсөн хууль тогтоомж, дүрэм журмын нэр, зүйл заалтын дугаар, тэдгээрийн товч утга, буруутай этгээдийн нэр, албан тушаалыг тодорхой бичнэ.

Илэрсэн зөрчил дутагдал, түүнээс үүссэн хохирлыг баримтжуулсан фото зураг, дууны болон дүрсний бичлэг, шинжээчийн дүгнэлт, лабораторийн шинжилгээ жураах орлого, үүссэн хохирлын тооцоо зэргийг хавсаргана.

*б/тогтоох хэсэгт:*

-Зөрчил, дутагдал гаргасан этгээдэд хүлээлгэх нөхөн төлбөрийн үндэслэлийг холбогдох хууль тогтоомжийн нэр, зүйл заалт, тэдгээрийн товч утгыг зааж зөрчлийг таслан зогсоохын тулд ямар арга хэмжээ авахыг тодорхойлсон байх;

-Төлүүлэхээр шийдвэрлэсэн хохирлыг ямар аж ахуйн нэгж байгууллага, албан тушаалтан, иргэн хариуцах, үүссэн хохирол, хууль бус орлогын хэмжээ, түүнийг төлөх болон үйл ажиллагааг зогсоох хугацаа;

-Шалгаж акт тогтоохтой холбогдон гарсан зардлын хэмжээ /лабораторийн шинжилгээ хийлгэсэн, эмжин шалгах техник хэрэгсэл ашигласан зэрэг/ түүнийг хариуцан төлөх этгээд, аль байгууллагын ямар дансанд төлөх, түүний

хугацаа.

*в/ баталгаажуулалтын хэсэгт:*

-Акт тогтоосон улсын байцаагчийн нэр, гарын үсэг, тэмдэг;

-Акттай танилцаж зөвшөөрсөн тухай байгууллагын албан тушаалтан, хариуцагч этгээдийн нэр, гарын үсэг;

4. Акттай танилцсан хүмүүс түүнийг хүлээн зөвшөөрөөгүй тохиолдолд түүний тайлбарыг авч актанд хавсаргах ба тухайн хариуцагч этгээд гомдлоо актыг хүлээн авсан өдрөөс хойш 10 хоногийн дотор шалгалт хийсэн байгууллагын эрх баригчид буюу дээд шатны байцаагчид гаргаж болно.

*Гурав. Актыг хэрэгжүүлэх*

1. Шалгалт хийсэн улсын байцаагч нь акт холбогдох хавсралт баримт бичгийн 1-р хувийг тухайн актыг тогтоосон улсын байцаагч өөрийн байгууллагын албан хэрэгт хадгалж бусад хувийг холбогдох этгээдэд тус тус өгнө.

2. Актын биелэлтэнд тухайн актыг тогтоосон улсын байцаагч хяналт тавьж биелэлтийг хангуулах арга хэмжээ авна.

3. Актаар тогтоосон төлбөрийг хугацаанд нь төлөөгүй буюу актыг зөвшөөрөөгүй тохиолдолд нөхөн төлбөрийг холбогдох албан тушаалтан, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас гаргуулахаар шүүхэд нэхэмжилж шийдвэрлүүлнэ.

## МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙДЫН ТУШААЛ

2000 оны 3 дугаар сарын 02-ны өдөр

Дугаар 33

Улаанбаатар хот

Журам батлах тухай

"Монгол Улсын 2000 оны төвлөрсөн төсвийн тухай" хууль, Засгийн газрын 2000 оны 6, 14, 21 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор **ТУШААХ** нь:

Нэг. Төвлөрүүлэн захирагчдад санхүүжилт олгох, хяналт тавьж төсвийн гүйцэтгэлийг зохион байгуулах, тайлагнах журам"-ыг хавсралтаар баталсугай.

Хоёр. Энэхүү журмыг 2000 оны 2 дугаар сарын 29-ний өдрөөс эхлэн мөрдүүлж, гүйцэтгэлд нь хяналт тавьж ажиллахыг Төрийн сангийн газар /Х.Пүрэвсүрэн/, Мэдээлэл хяналт-шинжилгээ, үнэлгээний газар /Ц.Даваасүрэн/, Санхүүгийн улсын хяналт шалгалтын газар /Г.Зинаамядар/-т даалгасугай.

САНГИЙН САЙД

Я.ОЧИРСҮХ

*Сангийн сайдын 2000 оны 33 дугаар тушаалын хавсралт*

### ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧДАД САНХҮҮЖИЛТ ОЛГОХ, ХЯНАЛТ ТАВЬЖ ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙГ ЗОХИОН БАЙГУУЛАХ, ТАЙЛАГНАХ ЖУРАМ

1. Төсвийн төвлөрүүлэн захирагчийн эрх олгогдсон Батлан хамгаалах яам, Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын яам, Хууль зүйн яам болон Засгийн газрын шийдвэрээр холбогдох эрх олгогдсон бусад байгууллага /цаашид "төсвийн

төвлөрүүлэн захирагч" гэж нэрлэнэ/-д урсгал зардлын санхүүжилтийг олгох, хяналт тавьж төсвийн гүйцэтгэлийг зохион байгуулах, зардлын мэдээ, тайланг хүлээн авахад энэхүү журмыг мөрднө.

2. Зэвсэгт хүчний болон хилийн цэргийн анги, нэгтгэл, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын байгууллагууд, шүүхийн шийдвэр биелүүлэх болон хорих байгууллагууд, цагдаагийн газар, хэлтэс, анги, нэгтгэл, шүүхийн байгууллагуудын үйл ажиллагааны урсгал зардлыг төсвийн төвлөрүүлэн захирагчдаар дамжуулан санхүүжүүлнэ.

3. Төсвийн төвлөрүүлэн захирагч нь Сангийн яамны Төсвийн бодлогын газар, Төрийн сангийн газраас зөвшөөрөл авч банкнд санхүүжилтийн харилцах данс нээнэ.

4. Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харилцах дансны 1 дүгээр болон 2 дугаар гарын үсгийг зурах албан тушаалтнуудын нэр, албан тушаал, гарын үсгийн баталгааг Сангийн яаманд ирүүлж албан ёсны зөвшөөрөл авч байна.

5. Төсвийн төвлөрүүлэн захирагчдаас төсвийн шууд захирагчдад олгох санхүүжилтийг дараах дарааллыг баримтлан олгоно:

а/ цалин хөлс, нэмэгдэл урамшил болон түүнтэй адилтгах зардал;

б/ нийгмийн даатгалын шимтгэл, эрүүл мэндийн даатгалын хураамж;

в/ хоолны зардал;

г/ эмийн зардал;

д/ бусад зардал.

6. Гэрэл цахилгаан, түлш халаалт, шуудан холбоо, цэвэр бохир болон халуун усны зардлын үндсэн баримтыг үндэслэн Сангийн яамнаас шууд үйлчлэгч аж ахуйн нэгж, байгууллагад шилжүүлнэ. Үйлчлэгч аж ахуйн нэгж, байгууллагын төлбөрийн нэхэмжлэлд төсвийн шууд захирагчаас үнэн зөв болохыг нотолсон гарын үсэг, тамга, тэмдгийг дарж ирүүлсэн баримтыг үндэслэн төсвийн төвлөрүүлэн захирагч жагсаалт хийж Сангийн яаманд ирүүлнэ.

Энэ нь уг зардлын суутган тооцоололт хийх үндсэн баримт болно.

7. Төсвийн төвлөрүүлэн захирагч нь Улсын Их Хурлаар батлагдсан 2000 оны төлөвлөгөөг баримтлан төсвийн шууд захирагчдад санхүүжилтийг олгох бөгөөд байгууллагын дүнгээр батлагдсан төсвийн хэмжээг өөрчлөх эрхийг эдлэхгүй.

8. Төсвийн төвлөрүүлэн захирагчийн буруутай үйл ажиллагаатай холбоотойгоор төсвийн шууд захирагчийн цалин хөлс, нэмэгдэл урамшил, нийгмийн даатгалын шимтгэл болон эрүүл мэндийн

даатгалын хураамж, хоол, эмийн зардлын санхүүжилтийг саатах, үүнээс үүдэн гарах аливаа сөрөг үр дагаврын хариуцлагыг төсвийн төвлөрүүлэн захирагч хүлээнэ.

9. Төсөвт байгууллагуудын батлагдсан зардлаас илүү нэмэгдэл зардал гарган зах зээлийн дундаж үнийн түвшинээс өндөр үнээр болон зээлээр бараа, бүтээгдэхүүн, үйлчилгээ худалдан авч өр авлага үүсгэснээс гарах үр дагаврыг холбогдох гэм буруутай ажилтан хариуцна.

10. Төсвийн төвлөрүүлэн захирагч нь төсвийн шууд захирагчийн батлагдсан зардлыг хасах замаар төвлөрүүлж, өөрийн мэдлийн хөрөнгийн эх үүсвэр, фонд байгуулахыг хориглоно.

11. Төсвийн төвлөрүүлэн захирагч болсон байгууллагууд нь нэмэгдэл аливаа ажлын орон тоо шинээр бий болгох, нэмэгдэл зардал гаргахыг хориглоно.

12. Төсвийн төвлөрүүлэн захирагч нь батлагдсан урсгал зардлыг хөрөнгийн зардалд зориулан шилжүүлэхийг хориглоно.

13. Улсын төвлөрсөн төсвөөс хөрөнгө оруулалтын зардлыг төсвийн төвлөрүүлэн захирагчдад олгохгүй бөгөөд Сангийн сайдын 1998 оны 66 тоот тушаалаар батлагдсан журмыг үндэслэн санхүүжүүлнэ.

14. Төсвийн төвлөрүүлэн захирагч нь нэгдсэн тайлан, мэдээг төсвийн ангиллын дагуу бүрэн зөв гаргаж хугацаанд нь ирүүлэх үүрэг хүлээнэ.

15. Батлагдсан төсвийн сарын гүйцэтгэлийн мэдээг төсвийн шууд эрх захирагчдаас сарын эцсийн өдөр авч дараа сарын 2-ны дотор, хагас жилийн тайланг 7 дугаар сарын 15-ны дотор авч нэгдсэн тайланг 8 дугаар сарын 5-ны дотор, жилийн тайланг дараа оны 1 дүгээр сарын 10-ны дотор авч нэгдсэн тайланг 2 дугаар сарын 20-ны дотор төсвийн ангиллаар Сангийн яаманд ирүүлнэ.

16. Төсвийн төвлөрүүлэн захирагч нь санхүүжилтийг шууд эрх захирагч нарт олгож, тайлан мэдээг хүлээн авч нэгтгэн Сангийн яаманд ирүүлнэ.

17. Энэ журмыг зөрчсөн тохиолдолд төсвийн төвлөрүүлэн захирагчийн эрхийг шилжүүлэх асуудлыг Сангийн яамнаас холбогдох дээд байгууллагад тавьж шийдвэрлүүлэх болно.



## МОНГОЛ УЛСЫН ДЭД БҮТЦИЙН ХӨГЖЛИЙН САЙДЫН ТУШААЛ

2000 оны 2 дугаар сарын 21-ны өдөр

Дугаар 56

Улаанбаатар хот

**Зураг төслийн ажлын жишиг үнэ, заавар батлах тухай**

Монгол Улсын "Барилгын тухай" хуулийн 6 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2-т заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. "Иргэн, үйлдвэрийн барилга, хот байгуулалт, өндөр хүчдэлийн шугам, дэд станцын зураг төслийн ажлын жишиг үнэ"-ийг нэгдүгээрт хавсралтаар, "Зураг төслийн ажлын жишиг үнэ хэрэглэх заавар"-ыг хоёрдугаар хавсралтын дагуу баталж мөрдүүлсүгэй.

2. Батлагдсан жишиг үнийг үндэс болгон гэрээ, хэлцэл байгуулж байхыг зураг төслийн болон захиалагч байгууллага, аж ахуйн нэгжийн эрх баригчид зөвшөөрсүгэй.

3. Хэрэглээний үнэ, тарифын өөрчлөлттэй уялдуулан ДБХЯ-ны Стратегийн төлөвлөлт, нэгдсэн бодлогын газартай тохиролцооны үндсэн дээр зураг

төслийн жишиг үнийг зохицуулах итгэлцүүрийг жил тутам шинэчлэн баталж мөрдүүлэхийг Барилга, архитектурын газар /н. Лхагвасүрэн/-т зөвшөөрсүгэй.

4. Барилга архитектурын газар /агентлаг/-аас 2000 оны эхний хагас жилд багтаан боловсруулж батлуулах зураг төслийн ажлын жишиг үнэ боловсруулах жагсаалтыг гуравдугаар хавсралтын дагуу баталж зохих хяналт тавьж ажиллахыг СТНБГ /н. Буд/-т даалгасугай.

5. Энэ тушаал гарсантай холбогдуулан Барилга, хот байгуулалтын сайдын 1993 оны 23 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД

Г.БАТХҮҮ

*ДБХ-ийн сайдын 2000 оны 56 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт*

### А. ИРГЭН, ҮЙЛДВЭРИЙН БАРИЛГЫН ЗУРАГ ТӨСЛИЙН АЖЛЫН ЖИШИГ ҮНЭ

#### 1. Барилга

Хүснэгт 1

№ Барилгын төрөл	1 м2-д ногдох жишиг үнэ	Бүүрүүлэх итгэлцүүр							
		500 м <sup>2</sup> хүртэл	501-700 м <sup>2</sup>	701-800 м <sup>2</sup>	801-1500 м <sup>2</sup>	1001-1500 м <sup>2</sup>	1500-2000 м <sup>2</sup>	2001-с дээш	2500-с дээш
1.1 Иргэн, орон сууц олон нийтийн барилга	7588	1.0	0.95	0.9	0.8	0.75	0.65	0.6	0.55
1.2 Үйлдвэр, үйлчилгээний барилга	6504	1.0	0.95	0.9	0.8	0.75	0.65	0.6	0.5

#### 2. Гадна инженерийн шугам сүлжээ /1у/м-ийн үнэ тогроогоор/

Хүснэгт 2

№ Зургийн нэр	10 м хүртэл	100 м хүртэл	300 м хүртэл	500 м хүртэл	1000 м хүртэл	1500 м хүртэл	2000 м хүртэл	2500 м хүртэл	3000 м хүртэл	3500 м хүртэл
2.1 Гадна дулааны шугам	13008	7805	6244	4995	3994	3198	2558	2048	1625	1301
2.2 Гадна цэвэр усны шугам	4336	3469	2710	2168	1084					
2.3 Гадна бохир усны шугам	4878	3794	3252	2710	1626					
2.4 Гадна цахилгааны кабель шугам /6 кв хүртэл/	3035	1734	1301	1084						
2.5 Гадна цахилгааны кабель /1 кв хүртэл/	2710	1626	1192	975						
2.6 Гадна цахилгааны агаарын шугам	2493	1469	975	759						
2.7 Гадна холбооны агаарын шугам	2385	1301	867	650						
2.8 Гадна холбооны кабель шугам	2385	1301	867	650						

Тайлбар: 1. Гадна дулааны үнэ нь нэг сувгаар 100-150 мм диаметртэй 2 яндантай үеийн үнэ ба яндангийн тоо дивметрээс хамааруулан дор дурдсан итгэлцүүрийг хэрэглэнэ. Үүнд:

1.1. Нэмжгэдэх яндангийн тоо тутамд -1.1

1.2. Диаметрээс хамаарч



Хүснэгт 3

Диаметр/мм/	50 хүртэл	70-80	200-250	300-350	400-450	500-аас дээш
Итгэлцүүр	0.47	0.61	1.6	2.1	2.8	4.0

### 3. Инженерийн барилга байгууламж

#### 3.1 Элеваторын үзель:

Хүснэгт 4

Элеватор №	1-3	4-5	6-7
Үнэ /төг/	27100	35230	45799

#### 3.2. Дулааны пункт /ЦТП/

Тусдаа барилгатай нэг пункт 1075328 төг

3.2.1. Нэг барилгад - 916728 төг

3.2.2. Хороололд - 1517600

#### 3.4. Халаалтын зуух

Зуухны хүчин чадлын 1 Гкал /цаг тутамд 776144 төг

Тайлбар: Уурын тогоо бүхий зуухны үнийг дээрх үнэд 1.15 коэффициент хэрэглэж гаргана.

##### 3.4.1. Цэвэрлэх байгууламж

Хүснэгт 5

Хүч чадал	Сая төг
50 м3 хүртэл	1.8
100 м3 хүртэл	3.0
500 м3 хүртэл	4.1
1000 м3 хүртэл	6.3
2700 м3 хүртэл	8.0
4200 м3 хүртэл	10.2
4300-аас дээш	13.0

##### 3.4.2. Цэвэрлэх байгууламжийн барилга байгууламж

Хүснэгт 6

Хүч чадал	Сая төгрөг
Насосны станцын 1 барилга	0.19
Тунгаагч	0.02
Шүүр, бутлагч	0.16
Элсний талбай	0.02
Блок ёмкость	0.29
Үйлдвэрийн корпус	0.69
Биологийн цөөрөм	0.08
Хлоржуулагч	0.43

#### 3.5. Цэвэр усны насос станц

Хүч чадал	Сая төгрөг
50м3 хүртэл	0.30
100 м3 хүртэл	1.55
500 м3 хүртэл	0.75
1000 м3 хүртэл	0.97
2700 м3 хүртэл	1.20
4200 м3 хүртэл	1.49
4300-аас дээш	1.95

## 3.6. Усан сан

Хүснэгт 8

Хүч чадал	Сая төгрөг
50 хүртэл	0.28
300 м3 хүртэл	0.32
500 м3 хүртэл	0.39
1000 м3 хүртэл	0.65
1001-ээс дээш	25 хувь өсгөнө.

## 3.7. Бохирын цооног

Хүснэгт 9

Хүч чадал, м3/хоногт	Сая төгрөг
50 хүртэл	0.28
135 хүртэл	0.32
135-аас дээш	0.38

 3.8. Агаарын трансформатор -0.12-0.15 сая төгрөг  
 Дэд өртөө -0.30-0.40 сая төгрөг

## 3.9. Дизель цахилгаан станц

Хүснэгт 10

Хүч чадал	Сая төгрөг
100 хүртэл	13.0
200 хүртэл	10.8
400 хүртэл	8.6
1000 хүртэл	7.0

 ИРГЭН, ҮЙЛДВЭРИЙН БАРИЛГЫН ЗУРАГ ТӨСЛИЙН АЖЛЫН  
 ҮНИЙН ХУВААРИЛАЛТ /хувиар/

Хүснэгт 11

Нэр	Орон сууц	Олонний-тийн	Үйлдвэрийн	Зуухны	ЦТП	Биологийн цэвэрлэх байгууламж		Механик цэвэрлэх байгууламж	Дизель цахилгаан станц
						Энгийн	Зохиомол		
Зургийн ерөнхий инженер	5	5	5	5	5	5	5	5	5
Архитектур, барилгын бүтээц	58	52	52	34	24	48	27	27	26
Калаалт, салхивч	7	7	7	3	4	-	7		5
Цэвэр бохир ус	7	7	7	3	3	-	--	7	3
Цахилгаан	7	7	8	8	7	-	8	8	15
Автоматик	4	-	8	11	13	-	14	14	13
Холбоо дохиолол	2	3	3	-	-	-	2	2	2
Технологи	-	8	-	30	34	37	27	27	21
Төсөв	10	11	10	10	10	10	10	10	10
ДҮН	100	100	100	100	100	100	100	100	100

 Б. ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЗУРАГ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ  
 АЖЛЫН ЖИШИГ ҮНЭЛГЭЭ /сая төгрөгөөр/

Хүснэгт 12

Ажлын төрөл	Үнэ
1. Нутагшилтын ерөнхий төсөл, бүс нутаг, аймаг хөгжүүлэх төсөл	
500 мянган км <sup>2</sup> хүртэл	11.9
100 мянган км <sup>2</sup> хүртэл	14.1
200 мянган км <sup>2</sup> хүртэл	15.1
500 мянган км <sup>2</sup> хүртэл	16.0
1000 мянган км <sup>2</sup> хүртэл	17.6
10000 мянган км <sup>2</sup> -аас дээш	18.8

2. Бичил бүсүүдийн төлөвлөлт, нутаг дэвсгэр, үйлдвэрлэлийн цогцолборын төлөвлөлт, бүлэг суурингийн хөгжлийн төсөл, амралт сувилал, аялал жуулчлалыг хөгжүүлэх төсөл, томоохон хот орчмын болон бусад салбарын төсөл	1 мянган м <sup>2</sup> хүртэл 5 мянган м <sup>2</sup> хүртэл 10 мянган м <sup>2</sup> хүртэл 20 мянган м <sup>2</sup> хүртэл 20 мянган м <sup>2</sup> -аас дээш	1.9 2.6 3.0 4.1 5.4
3. Хот, тосгоны ерөнхий төлөвлөгөө		
3.1. Хот, тосгоны ерөнхий төлөвлөгөө		
1 мянган хүнтэй		1.3
2 мянган хүнтэй		1.5
5 мянган хүнтэй		1.7
10 мянган хүнтэй		2.0
25 мянган хүнтэй		3.2
50 мянган хүнтэй		5.2
100 мянган хүнтэй		7.1
250 мянган хүнтэй		10.3
250 мянгаас дээш хүнтэй		17.3
3.2. Ерөнхий төлөвлөгөөний бүсчлэлийн төлөвлөлт		
50 хүртэл га		2.8
100 га		3.4
250 га		4.1
500га		5.7
500-аас дээш га		6.7
4. Хот суурины төлөвлөлтийн хязгаарын төсөл		
1 мянга хүртэл хүнтэй		2.1
2 мянган хүнтэй		2.3
5 мянган хүнтэй		2.6
25 мянган хүнтэй		4.1
100 мянган хүнтэй		5.7
250 мянган хүнтэй		7.1
250-аас дээш хүнтэй		10.2
5. Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө		
50 хүртэл га		3.1
100 га		5.8
250 га		7.7
500 га		8.9
500-аас дээш га		9.8
6. Үйлдвэрлэлийн бүсийн төлөвлөлт дэх иргэн, орон сууцны хэсгийн ерөнхий төлөвлөгөө		
5 мянга хүртэл хүнтэй		
10 мянган хүнтэй		
25 мянган хүнтэй		
50 мянган хүнтэй		
50 мянгаас дээш хүнтэй		
7. Ажлын зургийн ерөнхий төлөвлөгөө, тохижилт		
0.5 га		
1 га		
5 га		
10 га		
25 га		
50 га		

*Тайлбар:*

1.1. Байгаль хамгаалал, байгалийн баялгийг ашиглах нутаг дэвсгэр зохион байгуулалтын цогцолбор болон нутагшилтын төслийг боловсруулахдаа захиалагчтай тохиролцсоны үндсэн дээр төлөвлөлтийн хүндрэл, төвөгшлийг харгалзан хүснэгт 1-ийн 1 дэх үнийг зохих итгэлцүүрээр өсгөн авч болно.

1.2. Жишиг үнийн 3.1-д хот суурины хөгжлийн төлөвлөлтийн чиг хандлага /концепци/ тодорхойлох ажлын үнэ ороогүй. Хот суурины хөгжлийн төлөвлөлтийн чиг хандлага /концепци/-ийг дангаар боловсруулах ажлын үнийг тодорхойлохдоо 3.1 дэх үнийг 50 мянга хүртэл хүнтэй бол 0.5, 50 мянгаас дээш хүнтэй бол 0.7 гэсэн итгэлцүүрээр үржүүлнэ.

1.3. Ерөнхий төлөвлөгөөг хот суурины хөгжлийн төлөвлөлтийн чиг хандлага /концепци/ тодорхойлох ажлын хамт боловсруулах бол 3.1 дэх үнийг 50 мянга хүртэл хүнтэй бол 1.2, 50 мянгаас дээш хүнтэй бол 1.4 гэсэн итгэлцүүрээр үржүүлэн өсгөж хэрэглэнэ.



**В. Ерөнхий төлөвлөгөөний макет хийх /мян. төг-оор/**

Хүснэгт № 13

Ажлын төрөл		Үнэ		
1. Газрын гадаргын загвар	M1:1000 1 дм <sup>2</sup> -аар	1 зэрэг	3.8	
		П зэрэг	4.3	
		Ш зэрэг	4.8	
	M1:2000 1 дм <sup>2</sup> -аар	1 зэрэг	2.8	
		П зэрэг	3.2	
		Ш зэрэг	3.7	
	2. Барилга байгууламжийн эзлэхүүн төлөвлөлтийн загвар	M1:1000 1 дм <sup>2</sup> -аар	1 зэрэг	7.8
			П зэрэг	9.2
			Ш зэрэг	10.1
M1:2000 1 дм <sup>2</sup> -аар		1 зэрэг	5.8	
		П зэрэг	6.9	
		Ш зэрэг	7.6	
3. Газрын гадаргын загвар		M1:1000 1 дм <sup>2</sup> -аар	1 зэрэг	3.8
			П зэрэг	4.3
			Ш зэрэг	4.8
	M1:2000 1 дм <sup>2</sup> -аар	1 зэрэг	2.8	
		П зэрэг	3.2	
		Ш зэрэг	3.7	
	4. Барилга байгууламжийн эзлэхүүн төлөвлөлтийн загвар	M1:1000 1 дм <sup>2</sup> -аар	1 зэрэг	7.8
			П зэрэг	9.2
			Ш зэрэг	10.1
M1:2000 1 дм <sup>2</sup> -аар		1 зэрэг	5.8	
		П зэрэг	6.9	
		Ш зэрэг	7.6	
5. Макетын тайлбар:		-газрын гадаргын загвар хийх үед		
		1 зэрэг- 4%		
		П зэрэг -8%		
	Ш зэрэг -8 %-иас дээш			
	налуутай			
	-эзлэхүүн төлөвлөлтийн загвар хийх үед			
	1 зэрэг- 30% хүртэл нягтралтай			
	П зэрэг -30-50% нягтралтай			
	Ш зэрэг -50 %-иас дээш нягтралтай			

-загварыг цаас ба зөөлөн материалаар хийвэл үнийг 20% бууруулна.

**ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЗУРАГ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ АЖЛЫН ҮНЭ ӨСГӨХ ИТГЭЛЦҮҮР**

Хүснэгт 14

Нөлөөлөх үзүүлэлтүүд	Хүснэгт 1 дэх жишиг үнийг өсгөх итгэлцүүр
Нутагшилтын ерөнхий төсөл, бүс нутаг, аймаг хөгжүүлэх төсөл:	
1. 20-иос дээш хот, төв суурин газартай бол	1.05-1.2
2. Инженерийн байгууламжийн асуудал шийдвэрлэхэд	1.05-1.2
3. Үйлдвэрлэлийн зориулалттай ашигт малтмалын орд газруудтай бол	1.1
4. Байгальд нөлөө үзүүлэхүйц сөрөг хүчин зүйлтэй бол	1.1-1.2
5. Амралт сувилал, аялал жуулчлалын нөөцтэй бол	1.2
Бичил бүсүүдийн төлөвлөлт, нутаг дэвсгэр, үйлдвэрлэлийн цогцолборын төлөвлөлт, бүлэг суурингийн хөгжлийн төсөл, амралт сувилал, аялал жуулчлал хөгжүүлэх төсөл, томоохон хот орчмын болон бусад салбарын төсөл:	
1. 3-аас дээш хот, төв суурин газруудтай бол	1.1-1.20
2. Инженерийн байгууламжийн асуудал шийдвэрлэхэд	1.1-1.25
3. Үйлдвэрлэлийн зориулалттай ашигт малтмалын орд газруудтай бол	1.1
4. Амралт сувилал, аялал жуулчлалын нөөцтэй бол	1.2

5. Амралт сувилал, аялал жуулчлалын нөөцтэй бол Биечил бүсүүдийн төлөвлөлт, нутаг дэвсгэр, үйлдвэрлэлийн цогцолборын төлөвлөлт, бүлэг суурингийн хөгжлийн төсөл, амралт сувилал, аялал жуулчлал хөгжүүлэх төсөл, томоохон хот орчмын болон бусад салбарын төсөл:	1.2
1. 3-аас дээш хот, төв суурин газруудтай бол	1.1-1.20
2. Инженерийн байгууламжийн асуудал шийдвэрлэхэд	1.1-1.25
3. Үйлдвэрлэлийн зориулалттай ашигт малтмалын орд газруудтай бол	1.1
4. Амралт сувилал, аялал жуулчлалын нөөцтэй бол	1.2
5. Байгальд сөрөг нөлөө үзүүлэхүйц сөрөг хүчин зүйлтэй бол	1.1
Ерөнхий төлөвлөгөө:	
1. Байгалийн нөхцөлийн хувьд хүндрэлтэй, нэмэлт нутаг дэвсгэрийн инженерийн бэлтгэл арга хэмжээ авах шаардлагатай /гадаргын налуу 0.005-аас бага, 0.05-аас их намагтай, усанд автагддаг, овойлт, суулттай хөрстэй талбайн нийт төлөвлөлт хийх газрын 30 хувиас дээш бол гэх мэт/	1.2-1.6
2. Барилга, инженерийн байгууламж, шугам сүлжээ, төмөр болон авто зам, гүүрийн барилга байгууламжийн эзлэх талбай нийт төлөвлөлт хийх талбайн 50 хувиас их бол	1.1-1.5
3. Үйлдвэрлэлийн зориулалттай ашигт малтмалын орд газар байрладаг бол	1.1-1.2
4. Аялал жуулчлал, амралт сувилал гэх мэт тусгай зориулалтын нутаг дэвсгэр оршдог бол	1.1-1.2
5. Экологийн хувьд хүнд нөхцөлтэй болон түүх соёлын дурсгалт зүйл хамгаалах арга хэмжээ авах бол	1.1-1.8
Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө:	
1. М1:1000 масштабээр зураглал хийх	1.25
2. Хотын төв, түүх, соёл, архитектурын дурсгалт зүйл, амралт сувиллын бүс төлөвлөх	1.1-1.3

**Тайлбар:**

2.1. Өсгөх итгэлцүүрийн бага утгыг нөлөөлөх хүчин зүйлүүдийн дунд зэргийн нөхцөлд, дээд утгыг нөлөөлөх хүчин зүйлүүдийн хамгийн төвөгшилтэй үед тус тус хэрэглэнэ.

-Монгол орны онцлогт тохирсон итгэлцүүр

## ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЗУРАГ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ АЖЛЫН ҮНИЙН ХУВААРИЛАЛТ /хувиар/

Хүснэгт 15

№	Ажлын төрөл	Нутаг дэвсгэрт хийгдэх иж бүрэн үнэмтээ	Архитектур төлөвлөлт	Эдийн засгийн хэсэг	Эрх зүйн болон нийгмийн судалгаа	Хүрээлэн буй орчны хамгаалах, эрүүлжүүлэх	Зам тээвэр	Икөөнерийн шугам сүлжээ	Тохирилгын ажигл	Аюулгүй /гамшгаас хамгаалах инженерийн багтгал орно/ байгуу лалтын ажигл
1.	Нутагшлын ерөнхий төсөл, бус нутаг, аймгийн хөгжлийн төсөл	10	18	28	3	15	5	12	3	6
2.	Бичиг бүсүүдийн төлөв- лөлт, нутаг дэвсгэр, үйлдвэрлэлийн цогцол- борын төлөвлөлт, бүлэг суурингийн хөгжлийн төсөл, амралт сувилал, агалал жуулчлал хөгжүүлэх төсөл.	6	25	28	3	14	4	12	3	5
2.1	Бичиг бүсүүдийн төлөвлөлт	6	23	30	3	14	5	11	3	5
2.2	Нутаг дэвсгэр үйлдвэрлэл- ийн цогцолбор	6	23	30	3	14	5	11	3	5
2.3	Амралт сувилал, агалал жуулчлалын болон бусад дад төслүүд	5	23	29	3	18	4	11	3	4
3.	Ерөнхий төлөвлөгөө.									

3.1 Хот, тосгоны ерөнхий төлөвлөгөө	10	28	18	5	10	8	12	4	5
3.2 Хот, тосгоны хөгжлийн төлөвлөлттэй чиг хандлага /концели/ тодорхойлох /тусад нь төлөвлөх үед/	10	25	20	5	10	10	12	3	5
3.3 Тусгайлан нутаг дэвсгэрийн ерөнхий төлөвлөгөө /суурьшлын, үйлдвэрийн, амралтын аялал жуулчлалын гэх мэт/	8	30	25	5	6	8	11	3	4
4 Хот, тосгоны төлөвлөлттэй хягаарын төсөл	5	15	10	-	-	70	-	-	-
5 Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө:									
5.1 Суурьшлын болон түүх дурсгалын холбогдолтой бус	5	35	15	4	6	11	15	5	4
5.2 Үйлдвэр аж ахуй, байгуулахы бус	4	31	18	5	5	12	15	55	5
5.3 Амралт сувиллын бус	4	34	16	4	12	10	14	4	2
5.4 Хотын тодорхой хэсэг, талбай гол гудам, Үйлдвэрийн бүсийн төлөвлөлт дэх иргэн орон сууцны хэсгийн ерөнхий төлөвлөгөө	4	42	12	3	4	15	14	4	2
7. Ахлын зургийн ерөнхий төлөвлөгөө	-	55	5	-	5	5	-	30	-

### ӨНДӨР ХҮЧДЭЛИЙН ШУГАМ, ДЭД СТАНЦЫН ЗУРАГ ТӨСЛИЙН ЖИШИГ ҮНИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 16

Шугам, дэд станцын нэр, хүчин чадал	Хэмжих нэгж	Нэгжид ногдох үнэ /төг/
<b>Өндөр, нас хүчдэлийн цахилгаан дамжуулах агаарын шугам</b>		
<b>А. 6-10 кВ-ын хүчдэлтэй</b>		
5 км хүртэл урттай	1 объект	232566
5-10 км	∴	243307
10-20 км	∴	350250
20-40 км	∴	466066
40 км-ээс дээш	∴	621110
<b>Б. 35 кВ-ын хүчдэлтэй, модон тулгууртай</b>		
5 км хүртэл урттай	1 объект	280387
5-10 км	∴	426791
10-20 км	∴	511972
20-40 км	∴	862455
40 км-ээс дээш	∴	1148166
<b>В. 35 кВ-ын хүчдэлтэй, төмөр төмөр бетон тулгууртай</b>		
5 км хүртэл урттай	1 объект	466197
5-10 км	∴	698856
10-20 км	∴	872692
20-40 км	∴	1412637
40 км-ээс дээш	∴	1806449
<b>Г. 110 кВ-ын хүчдэлтэй, төмөр, төмөр бетон тулгууртай</b>		
10 км хүртэл урттай	1 объект	803613

10-30 км	-:-	1007879
30-60 км	-:-	1951873
60-100 км	-:-	2811807
100 км-ээс дээш	-:-	3695277
Д. 220 КВ-ын хүчдэлтэй төмөр, төмөр бетон тулгууртай		
10 км хүртэл урттай	1 объект	1207101
10-30 км	-:-	1302089
30-60 км	-:-	2723544
60-100 км	-:-	4435005
100 км-ээс дээш	-:-	5547119
Е. Агаарын шугам		
1 км хүртэл урттай	-:-	66374
1-3 км	-:-	133562
3-5 км	-:-	174658
5 км-ээс дээш	-:-	249378
Е. 0.4-10 кВ-ын кабель шугам		
1 км хүртэл урттай	-:-	76588
1-3 км	-:-	92466
3-5 км	-:-	103674
5 км-ээс дээш	-:-	115816
Өндөр хүчдэлийн дэд өртөө		
А. 35/6.10 кВ-ын хүчдэлтэй		
400 кВА хүртэл чадалтай 1 трансформатортой	-:-	1167500
400 кВА хүртэл чадалтай 2 трансформатортой	-:-	1690306
630 кВА чадалтай 1 трансформатортой	-:-	1517283
630 кВА чадалтай 2 трансформатортой	-:-	1926949
1000 кВА хүртэл чадалтай 1 трансформатортой	-:-	1538298
1000 кВА хүртэл чадалтай 2 трансформатортой	-:-	1958598
1600 кВА хүртэл чадалтай 1 трансформатортой	-:-	16477576
1600 кВА хүртэл чадалтай 2 трансформатортой	-:-	2118312
2500 кВА хүртэл чадалтай 1 трансформатортой	-:-	1773666
2500 кВА хүртэл чадалтай 2 трансформатортой	-:-	2294838
4000 кВА хүртэл чадалтай 1 трансформатортой	-:-	1916568
4000 кВА хүртэл чадалтай 2 трансформатортой	-:-	2000628
6300 кВА хүртэл чадалтай 1 трансформатортой	-:-	2059470
6300 кВА хүртэл чадалтай 2 трансформатортой	-:-	2681514
35 кВ-ын хуваарилах байгууламжийн	1 ячек	366501
	/орго/	

Хуваарилах байгууламжийн өрөөний тоо 1-ээс дээш бол өмнөх үнэлгээг өрөөний тоогоор үржүүлж, гарсан дүнг  $K=0.7$ -гоор бууруулж авна.

Б. 35/0.4 кВ-ын хүчдэлтэй

125 кВА хүртэл чадалтай	-:-	546390
160 кВА чадалтай	-:-	588420
200 кВА	-:-	672480
250 кВА	-:-	756540
400 кВА	-:-	924660
630 кВА	-:-	1008720

В. 110/10 кВ-ын хүчдэлтэй /1-2 трансформатортой/

6300 кВА хүртэл чадалтай 1 трансформатортой	-:-	3169062
6300 кВА хүртэл чадалтай 2 трансформатортой	-:-	3513708
10000 кВА хүртэл чадалтай 1 трансформатортой	-:-	3580956
10000 кВА хүртэл чадалтай 2 трансформатортой	-:-	3976038
16000 кВА хүртэл чадалтай 1 трансформатортой	-:-	4051692
16000 кВА хүртэл чадалтай 2 трансформатортой	-:-	4514022
110 кВ-ын хуваарилах байгууламж /ХБ/-ийн	1 ячек	790164
	/орго/	

Хуваарилах байгууламжийн өрөөний тоо 1-ээс дээш бол үнэлгээг өрөөний тоогоор үржүүлж, гарсан дүнг  $K=0.8$ -гоор бууруулж авна.


**Г. 110/35/10 кВ-ын хүчдэлтэй /1-2 трансформатортой/**

6300 кВА хүртэл чадалтай 1 трансформатортой	-,-	3665016
6300 кВА хүртэл чадалтай 2 трансформатортой	-,-	5539554
10000 кВА хүртэл чадалтай 1 трансформатортой	-,-	4001256
10000 кВА хүртэл чадалтай 2 трансформатортой	-,-	6052320
16000 кВА хүртэл чадалтай 1 трансформатортой	-,-	4354308
16000 кВА хүртэл чадалтай 2 трансформатортой	-,-	6615522
110 кВ-ын хуваарилах байгууламж /ХБ/-ийн	1 ячек /өрсө/	790164

Хуваарилах байгууламжийн ерөөний тоо 1-ээс дээш бол өмнөх үнэлгээг ерөөний тоогоор үржүүлж, гарсан дүнг  $K=0.7$ -гоор бууруулж авна.

**Д. Өндөр үелэлэлийн холбоо**

35-ын шугам	1 шугам	336240
110-ын шугам	-,-	563202
220-ын шугам	-,-	680886

Тайлбар:

1. Хоёр хэлхээтэй 35-220 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугамын зураг төслийн үнийг 1 хэлхээтэй 35-220 кВ-ын шугамын дээрх үнийг  $K=1.3$ -аар өсгөж авна.

2. Нэг сувагт 2 буюу түүнээс дээш кабель зэрэгцээ байрлах тохиолдолд зураг төслийн үнийг  $K=1.1-1.3$ -аар өсгөж авна.

3. 220/110/35 кВ-ын дэд өртөөний зураг төслийн үнийг 110/35/10 кВ-ын дэд өртөө болон 110 кВ-ын хуваарилах байгууламжийн харгалзах хүчин чадлын зураг төслийн үнийг  $K=1.5$ -аар өсгөж авна.

**ӨНДӨР ХҮЧДЭЛИЙН ШУГАМ, ДЭД СТАНЦЫН ЗУРАГ  
ТӨСЛИЙН АЖЛЫН ҮНИЙН ХУВААРИЛАЛТ /хувиар/**

Хүснэгт 17

Нэр	Өндөр хүчдэлийн шугам	Дэд станц					Холбоо
		220/110/10-6 кВ	110/35/10-60кВ	110/10-6кВ	35/10/6 кВ	35/0.4 кВ	
Зургийн ерөнхий инженер	5	5	5	5		5	10
Шугам	85						
Дэд станцын ахлагч	22	32	32	32		46	
Реле хамгаалалт		28	28	28	28	6	
Автомат		8	8	8	6	9	
Нарийн хэмжүүр		4	4	4	5	8	
Холбоо							90
Барилга		22	12	12	14	10	
Төсөв	10	11	11	11	10	11	10
ДҮН	100	100	100	100	100	100	100

## ЗУРАГ ТӨСЛИЙН АЖЛЫН ЖИШИГ ҮНЭ ХЭРЭГЛЭХ ЗААВАР

Хот төлөвлөлтийн болон барилга байгууламжийн зураг төсөл боловсруулахаар зураг төсөл зохиогч, захиалагч байгууллагын хооронд аж ахуйн гэрээ байгуулахад хэрэглэх зураг төслийн үнийг тохиролцох жишиг үнийг тогтооход энэ зааврыг хэрэглэнэ.

2. Энэхүү жишиг үнэ нь тухайлсан барилга байгууламжийн зураг төслийг шинээр боловсруулах ажлын үнэлгээ бөгөөд давтан хэрэглэх буюу нэг маягийн зураг төсөлд холболт хийхэд тухайн зураг төслийн үнийн 30 хүртэл хувиар тооцно.

3. Үнэлгээнд норм дүрэм, альбом, каталог боловсруулах ажил, геодези зураг зүй, инженер хайгуулын ажил, авто замын гүүр, төмөр зам, өндөр хүчдэлийн шугам, үеийн хамгаалалтын болон хотын дулаан, цэвэр, бохир усны төв шугам, хот хоорондын цахилгаан холбоо, радио релейний шугамын ажлын зураг төслийн ажлын үнэ тусгагдаагүй ба түүний үнэлгээг тухайн ажлыг эрхэлдэг мэргэжлийн байгууллагын оролцоотойгоор боловсруулан баталж мөрдүүлнэ.

4. Барилгын технологийн тоног төхөөрөмж, дамжуулах хоолой, тавилга, интерьерийн ажлын зураг төсвийн үнийг захиалагч, гүйцэтгэгч байгууллагууд харилцан тохиролцож тогтооно.

5. Үнэд зургийн даалгавар, техникийн нөхцөлийн тооцоо, архитектур төлөвлөлт, инженерийн тооцоо, барилга, халаалт, салхивч, цэвэр бохир ус, гэрэлтүүлэг, холбоо дохиолол, тухайн барилгын гадна холболтууд, тохижилт, өндөржилт, өндөр хүчдэлийн шугам, дэд өртөөний ажлын зураг төсөв хийх ажил, түүний оюуны үнэлэмж, хөндлөнгийн шүүлт хийх, холбогдох байгууллагуудтай зөвшөөрөлцөх,

олшруулахтай холбогдсон шууд зардлууд захиргаа аж ахуйн зардлууд орсон.

6. Үнийг байгаль цаг уурын ердийн нөхцөлд газар хөдлөлтийн 6 баллаар тооцсон ба газар хөдлөлийн 7,8,9 баллд  $k=1.05$ ,  $k=1.1$ ,  $k=1.15$  шинэ хийцийн технологийг анх удаа өөрийн оронд хэрэглэж байгаа бол  $k=1.2$ , жишиг үнэд барилгын давхрын өндрийг иргэн орон сууцанд 3м, үйлдвэр, үйлдвэр, үйлчилгээний барилгад 4,5 м байхаар тооцсон бөгөөд давсан 1 м тутамд 1.05 гэсэн итгэлцүүрийг тус тус хэрэглэнэ.

7. Зураг төсөлд захиалагчийн санаачилгаар төвөгшилтэй төлөвлөлт бүхий стандартын бус хийц эдлэхүүн хэрэглэж байгаа бол үнэлгээг захиалагчтай тохиролцон тусгайлан тодорхойлно.

8. Барилгын засварын зураг төсвийн үнийг зохиоходоо тухайн барилгын төсөвт өртгийн 2-3 хувиар тооцно.

9. Барилга байгууламжийг өөрчлөх, өргөтгөх, шинэчлэх үед тухайн өөрчилсөн хэсгийн зургийн үнийг тодорхойлоходоо 1.3 хүртэл итгэлцүүр хэрэглэж болно.

10. Эзлэхүүн буюу талбайгаар тооцох боломжгүй ил зогсоол, задгай засварын газар, хашаа, ил талбай, худаг саравч, мал шувуу бордох талбай, тарианы үтрэм зэргийн зураг төсвийн үнийг төсөвт өртгийн 1-4 хувиар тооцно.

11. Зааврын 3-р зүйлд заагдсан зураг төслийн ажлуудын болон техник эдийн засгийн үндэслэлийн ажлын үнэлгээг хөдөлмөр зарцуулалт /оюуны үнэлэмж/, тухайн ажлын хэрэгцээ, ач холбогдол зэргийг харгалзан зааврын 4-р зүйлд заасан энэ төрлийн зардлын хэмжээг захиалагч, гүйцэтгэгч байгууллагууд харилцан

тохиролцож тогтооно. Гэхдээ ажлын өртөг нь тухайн ажлын нийт төсөвт өртгийн 4 хувиас хэтэрч үл болно.

12. Нэгжид ногдох үнийг хүчин чадлаар үржүүлэн үндсэн үнийг олох ба хүндрэлийн зохих итгэлцүүрээр үржүүлэн зураг төсвийн жишиг үнийг тодорхойлно. Заагдсан хүч чадлын /1м2/ хоорондох нэгжийн үнийг интерполяцийн арга хэрэглэн тодорхойлно.

13. Энэхүү жишиг үнийг 2000 оныг дуустал мөрдөнө.

14. Боловсруулсан зураг төслийн төлөвлөлтийн шийдэл, ажлын хэмжээ, хэрэгсэл, нэг маягийн хийц, техникийн баримт бичиг, цахим тооцоолох хэрэгсэл ашигласан байдал зэргийг харгалзан үнийг туслан гүйцэтгэгч нарын хооронд хийсэн тохиролцоо, хэлцэл, гэрээний үндсэн дээр төслийн удирдагч хуваарилна. Зураг төслийн ажил эхлэхийн өмнө гэрээг хийх ба үнийн хуваарилалтыг тохирно.

15. Давтан хэрэглэгдэх зурагт технологийн болон төлөвлөлтийг 50 хувиас илүү өөрчлөх бол үнэлгээг шинэ зургаар хийнэ.

16. Хот төлөвлөлтийн зураг төсөл боловсруулах зураг төслийн ажлын үнийг хүснэгт 12-ыг үндэслэн тодорхойлох бөгөөд хот төлөвлөлтөд нөлөөлөх үндсэн хүчин зүйлүүдээс хамааран хийх ажилд гарах зардлыг тооцох итгэлцүүрийг тусгасан хүснэгт 13-ыг ашиглан өсгөж хэрэглэнэ.

17. Хот төлөвлөлтийн зураг төслийн ажлыг боловсруулахад нутаг дэвсгэрийн барилга байгууламжийг өөрчлөн шинэчлэх төвөгшлийг харгалзан зураг төслийн жишиг үнийг 1.5 хүртэлх итгэлцүүрээр өсгөн авч болно.

18. Хот төлөвлөлтийн зураг төсөв боловсруулах ажлын үнийг захиалагч, гүйцэтгэгч нар зургийн даалгавар, гэрээг

үндэслэн харилцан тохиролцсоны үндсэн дээр энэхүү жишиг үнээс багагүй байхаар тогтооно.

19. Жишиг үнэд зураг төсөл боловсруулах үндсэн үйл ажиллагааны зардлыг тооцож оруулсан бөгөөд нэмэгдсэн өртгийн албан татварын зардлыг тооцоогүй болно.

20. Хот төлөвлөлтийн зураг төсөл боловсруулах жишиг үнэд зураг төслийн ажлын өөрийн өртөг бүрдүүлэгч хөдөлмөр болон материал зарцуулалт гэх мэт зайлшгүй гарах зардлыг /27-д зааснаас бусад/ тооцож оруулсан. Энэхүү жишиг үнээр гүйцэтгэгдсэн байх зураг төслийн ажлын бүрдлийг ДБХЯ,БАГ /Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг/-аас тогтоож өгнө.

21. Хот төлөвлөлтийн зураг төслийн ажлын үнийг үе шатны ажилд хуваарилах болон туслан гүйцэтгэгч байгууллагаар хийлгэх ажлын үнэлгээг тодорхойлохдоо энэ жишиг үнийн хүснэгт 14-ийг үндэслэнэ.

22. Хот төлөвлөлтийн зураг төслийн ажил боловсруулах жишиг үнээр тогтоогдох үнэ нь зураг төсөл боловсруулах ба зураг төслийн баримт бичгийг баталгаажуулах ажлын үнэлгээнээс бүрдэнэ.

23. Жишиг үнийг үндэслэн тогтоогдох хот төлөвлөлтийн зураг төслийн ажил боловсруулах үе шатны ажил тус бүрийн үнэлгээг хүснэгт 14-ийн дагуу тодорхойлно.

Гэхдээ зураг төслийн байгууллага нь нийт зураг төслийн ажлын үнийн дүнд багтаан өөрийн хүчээр гүйцэтгэх үе шатны ажлын үнэлгээг өөрөө тогтоож болох ба туслан гүйцэтгэгч байгууллагаар гүйцэтгүүлэх үе шатны ажлын үнэлгээг тохиролцооны үндсэн дээр тогтооно. Ийм байдлаар хүснэгт 14-т тусгагдаагүй ажлын үнэ, үнэлгээг тодорхойлж болно.

24. Хүснэгт 14 дэх хот төлөвлөлтийн зураг





төсөл боловсруулах ажлын үнийн хуваарилалт нь шинээр боловсруулах ажилд хамаарах бөгөөд нутаг дэвсгэрийг өөрчлөн шинэчилж боловсруулах ажлын үнэ хуваарилалтад хэрэглэгдэхгүй.

25. Хот төлөвлөлтийн зураг төсөл боловсруулах ажлыг зураг төслийн нэг байгууллага бие даан гүйцэтгэх үед ажлын нийт үнэд багтаан хөдөлмөр зарцуулалтыг үндэслэн үнийн хуваарилалт хийж болно.

26. Захиалагч гүйцэтгэгч аж ахуйн нэгж, байгууллага нь хот төлөвлөлтийн зураг төсөл боловсруулах ажлын үнийг тохиролцооны үндсэн дээр тогтооно.

27. Хот төлөвлөлтийн зураг төсөл

боловсруулах ажлын жишиг үнэд дараах зардлуудыг тооцоогүй болно. Үүнд:

-Захиалагчийн баталсан зургийн даалгаварт тусгагдсаны дагуу төслийг нэмэлт хувилбараар тооцож боловсруулах ажил

-Зохиогчийн хяналтын зардал

-Эрдэм шинжилгээний судалгааны болон туршилтын ажлын зардал

-Гадаадын албан томилолтын зардал

-Захиалагчийн хүсэлтээр хийх нэмэгдэл ажлын зардал

-Газрын зураг болон инженер геологийн ажлын төсөл

-Зураг төслийн баримт бичгийг "Зураг төслийг боловсруулах, батлуулах заавар"-т зааснаас илүү тоогоор олшруулах зардал

*ДБХ-ийн сайдын 2000 оны 56 дугаар тушаалын гурицдугаар хансралт.*

## БАРИЛГА АРХИТЕКТУРЫН ЗУРАГ ТӨСӨЛ, ХАЙГУУЛЫН ЗАРИМ ЖИШИГ ҮНИЙГ 2000 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛД БАГТААН БОЛОВСРУУЛЖ БАТЛУУЛАХ ХУВААРЬ

Ажлын нэр	Хариуцан гүйцэтгэх байгууллага
1. Инженер хайгуулын ажил	Барилга архитектурын газар
2. Геодези зураг зүйн ажил	Геодези зураг зүйн газар
3. Усан цахилгаан станц	Эрчим хүчний удирдах газар
4. Дулааны болон дизель цахилгаан станц	Эрчим хүчний удирдах газар
5. Авто болон төмөр зам	Авто замын газар Төмөр замын хэрэг эрхлэх газар
6. Гүүр	Авто замын газар
7. Усны аж ахуйн барилга байгууламж	Геозкологийн хүрээлэн
8. Үерийн хамгаалалтын болон хотын дулаан, цэвэр, бохир усны төв шугам	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба
9. Холбооны хот хоорондын радиорелейний, хотын телефон радио, кабелийн телевизийн төв шугам	Цахилгаан холбоо компани

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.  
Хаяг: «Төрийн мэдээлэл» эмхтгэлийн зөвлөл

Улаанбаатар-12  
Төрийн ордон

☎ 329612  
Индекс 14003

Улсын Их Хурлын Тамгын газрын  
Хэвлэх хэсэгт хэвлэв.

☎ 329487